



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2023 оны 09 сарын 05 өдөр

Дугаар A/167

Улаанбаатар хот

“Гаүли ҮЦК” ХХК-ийн арилжаанд оролцох эрхийг түдгэлзүүлэх тухай

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, “Монголын хөрөнгийн бирж” хувьцаат компанийн Дүрмийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.9.3 дэх заалт, “Үнэт цаасны арилжаанд оролцох эрх олгох журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн 456 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Монголын Хөрөнгийн Бирж” ХК-ийн гишүүн “Гаүли ҮЦК” ХХК-ийн арилжаанд оролцох эрхийг 2023 оны 09 дүгээр сарын 06-ны өдрөөс эхлэн 3 сар хүртэл хугацаагаар түр түдгэлзүүлсүгэй.
2. Үнэт цаасны арилжааны программд нэвтрэх нэр, нууц үг хаах ажлыг Үйл ажиллагааны газрын Арилжааны алба /Д.Алдармаа/-нд, тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, зохицуулалтын газрын Хяналт, шинжилгээний алба /Д.Баттулга/-нд даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Х.АЛТАЙ

1523030368